



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 07 өдөр

Дугаар A/128

Арвайхээр

Тендерийн гүйцэтгэгчийг сонгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, 46 дугаар зүйлийн 46.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн 21 дүгээр зөвлөмжийн дагуу орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар санхүүжих Арвайхээр сумын ногоон байгууламжийг нэмэгдүүлэх тендерийн 1 дүгээр багц нийтийн эзэмшлийн талбайд мод бут, сөөг тарих ажлыг 100000000 (нэг зуун сая), 2 дугаар багц нийтийн эзэмшлийн талбайд олон наст хуйлдаг зүлэг тарих, хөрс бэлтгэх ажлыг 76000000 (далан зургаан сая) төгрөгөөр “Арвайхээр цэцэрлэгжилт” ОНӨААТҮГазар, 3 дугаар багц нийтийн эзэмшлийн талбайд олон наст таримал зүлэг тарих ажлыг Свебау Хаус ХХК 98680620 (ерэн найман сая зургаан зуун наян мянга зургаан зуун хорь) төгрөгөөр гүйцэтгүүлэхийг зөвшөөрсүгэй.

2. Гэрээ байгуулан, ажлын явцад хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд хүлээж авахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс (Г.Баясгалан)-т даалгасугай.

3. Гэрээнд заасан хуваарь, гүйцэтгэлийн дагуу санхүүжилт олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100287